

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2012 оны 1 дүгээр сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-12 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-12 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	177	11 <sup>1</sup>		188
3	Даатгалын төлөөлөгч	2029	28 <sup>2</sup>		2057
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			9
6	Актуарч	13			13
7	Бусад	10	2 <sup>3</sup>		12

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны даргын 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 03 дугаар тушаалаар “Ард даатгал” ХХК-д Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Дундговь аймгийн Мандалговь, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Хөвсгөл аймгийн Мөрөн, Төв аймгийн Зуунмод, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын болон Багануур дүүрэгт, Хорооны даргын 2012 оны 1 дүгээр сарын 09-ны өдрийн 05 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-д Завхан аймгийн Улиастай сум, Булган аймгийн Булган сумын нутаг дэвсгэрт тус тус даатгалын салбар нээн ажилуулахыг зөвшөөрсөн байна.

<sup>2</sup>Хорооны даргын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 08 дугаар тушаалаар “Мандал генерал даатгал” ХХК-ийн 14 иргэнд, Хорооны даргын 2012 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 14 дүгээр тушаалаар “Номин даатгал” ХХК-ийн 12 иргэнд, Хорооны даргын 2012 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн 2 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг олгосон байна.

<sup>3</sup>Хорооны 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Улаанбаатар хотын даатгал” ХХК, 02 дугаар тогтоолоор “Практикал даатгал”-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тус тус олгосон байна.

### 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2012 оны 01 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарынхтай харьцуулбал:

**Ердийн даатгалын компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөрөөр/	
		2011-I	2012-I
	Даатгалын нийт хураамж	910,215,852.0	3 655 134 785.53
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал		332 507 006.18
	Олгосон нөхөн төлбөр	404,565,632.0	923 860 021.85
	Үүнээс Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр		11 177 915.00
	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо		13
	Давхар даатгалд төлсөн хураамж	53,027,158.0	588 437 465.12
	Байгуулсан даатгалын гэрээний тоо	5,787	17340
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо		7201
	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо		9967
	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	200,000,000,000.0	23 548 694 400.00
	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	37,513,684.0	45 585 178.00

2012 оны 1 дүгээр сараас “Жолоочийн даатгалын тухай хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийг задалж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлого, нөхөн төлбөр гэж ангилсан.

2012 оны 1 дүгээр сарын байдлаар компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 2744.9 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 519.3 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 535.4 сая төгрөгөөр тус тус өсчээ.

2012 оны 1 дүгээр сард “Жонон даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.

Ердийн даатгалын компаниудын 2012 оны 1 дүгээр сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Монре даатгал” ХХК-ийн 23.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй даатгалын гэрээ байсан бол хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болох 45.6 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК олгосон байна.

#### Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	2011-I	2011-XII
1	Даатгалын нийт хураамж	2,570,746.2	29 534 576.20

2	Олгосон нийт нөхөн төлбөр	410,000.0	18 092625.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	5 325 200.00
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	11	11
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	6	2
	-Байгууллагын хугацаат даатгалд	1	-
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	4	-
	- Эмнэлгийн мөнгөний даатгалд		2
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		3
	-Тэтгэврийн даатгалд		4
	-Орон сууцны даатгалд		-
	-Хуримтлалын даатгалд		-
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		-
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10,000,000.0	400 000 000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	360,000.0	5 000 000.0

Урт хугацааны даатгалын компанийн 2012 оны 1 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын хураамжийн орлого 26.9 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 17.7 сая төгрөгөөр, давхар даатгалын хураамж 5.3 сая төгрөгөөр тус тус өсч, хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ нь 400.0 сая төгрөг, хамгийн их нөхөн төлбөр 5.0 сая төгрөг байсан байна.

#### Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-1 сар	2012-1 сар	Өсөлт бууралт
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	17,536,876.2	54 388 033.12	36 851 161.08
2	Даатгалын зуучлагчийн орлого	13,180,745.4	78 603 917.61	65 423 172.21
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	32	53	21
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	16,230,000,000.0	16 230 000 000.00	9 316 462 808.8

2012 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 54.4 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр

дүнтэй 16230.0 сая төгрөгийн үнэлгээтэй 5.5 сая төгрөгийн гэрээг “Асимон брокерс” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Монголиан интернэшнл брокерс” ХХК даатгалын зуучлалын орлогогүй ажилласан байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-1 сар	2012- 1 сар	Өөрчлөлт
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	4,252,185.2	10 013 072.00	5760 887.00
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	304	509	205
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	28,870,000.0	88 020 000.00	59 150 000

2012 оны 1 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 88.1 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 10.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК даатгалын хохирол үнэлсэн орлогогүй байна.

### 3. БУСАД

Хорооны 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлах тухай 04 дүгээр тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай шийдвэрүүдийг гаргасан байна.